



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН
АРБУЛАГ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2024 оны 09 сарын 26 өдөр

Дугаар 02

Арбулаг сум

Нэрэмжит болгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.3 дахь заалт, аймгийн соёл, урлагийн газрын 2024 оны 09 сарын 25-ны өдрийн 188 тоот албан бичиг, сумын Засаг даргын 2024 оны 09 сарын 25-ны өдрийн 1/229 тоот албан бичгийг тус тус үндэслэн Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит 17 дугаар хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Сумын соёлын төвийг Монгол улсын соёлын гавьяат зүтгэлтэн, утга зохиолын шүүмжлэгч, судлаач, доктор, профессор, яруу найрагч Чойсүрэнгийн Дагвадоржийн нэрэмжит болгосугай.

2. Тогтоолын сурталчилж, хэрэгжилтийг хангаж ажиллахыг сумын соёлын төвийн дарга (М.Хэнчиш)-д үүрэг болгосугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг нарийн бичгийн дарга (С.Бат-Эрдэнэ)-д үүрэг болгосугай.

ДАРГА



С. АЮУШЖАВ